

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН САНХҮҮ, ХАНГАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ХЭВЛЭХ, ОЛШРУУЛАХ ЦЕХИЙН АХЛАГЧИЙН АЛБАН
ТУШААЛЫН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР**

2022 оны 5 дугаар сарын 24-ний өдөр

Улсын Их Хурлын Тамгын газрын Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн Хэвлэх, олшруулах цехийн ахлагчийн албан тушаалын сул орон тоонд (1) сонгон шалгаруулалтыг нээлттэй зарлаж байна.

Нэг. Бүртгэлийн хугацаа

Бүртгүүлэхээр хүссэн иргэний хүсэлт, холбогдох баримт материалыг Улсын Их Хурлын Тамгын газрын Захиргаа, хүний нөөцийн хэлтэст хаяглан 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 09.00 цагаас 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 17.30 цагийн (сунгасан хугацаа) хооронд шуудангаар болон цахим tumentsetsegt@parliament.mn хаягаар хүлээн авна.

Иргэн бүртгүүлэхдээ өөрийн боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадвар, тусгай шаардлагын талаар дэлгэрэнгүй мэдээллийг үнэн зөв, товчилсон нэр, томъёо хэрэглэхгүй мэдээлэх шаардлагатай. Мөн холбоо барих утасны дугаар, гэрийн хаяг, И-мэйл хаяг зэргийг тодорхой дурдсан байна.

Хоёр. Албан тушаалын нэр, ангилал, тавигдах тусгай шаардлага

Албан тушаалын нэр: Хэвлэх, олшруулах цехийн ахлагч

Ангилал: Төрийн үйлчилгээний

АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА:		
Боловсрол		Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй.
Мэргэжил		- Үйлдвэрлэлийн менежмент; - Хэвлэлийн үйлдвэрлэлийн инженер технологи.
Мэргэшил		Хэвлэлийн график дизайнерайн мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байх.
Туршлага		Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх.
Ур чадвар	Багаар ажиллах	- Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; - Бусадтай харилцах итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - Багаар ажиллах, багийн амжилтыг үнэлэх, дүгнэх, нэгжийн хамт олонд таниулах; - Харилцааны оновчтой арга хэлбэрийг ашиглаж, мэдээллийг шуурхай хүргэх; - Бусад.

	Бусад	<ul style="list-style-type: none">- Компьютерийн хэрэглээний программ, интернет, и-мэйл зэрэг мэдээлэл харилцааны технологийг бүрэн ашиглах чадвартай;- Гадаад хэлний зохих мэдлэгтэй байх;- Төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг хэлбэрэлтгүй сахих.
--	-------	--

Гурав. Сонгон шалгаруулалтад бүртгүүлэхэд бүрдүүлэх баримт бичиг

1. Ажилд орохыг хүссэн өргөдөл;
2. Төрийн албан хаагчийн анкет (Маягт 1, Маягт 2);
3. Эзэмшсэн боловсрол, мэргэжлийн диплом, мэргэшүүлэх багц сургалтын болон бусад сургалтын гэрчилгээний хуулбар;
4. Ажиллаж байсан байгууллагын ажил байдлын тодорхойлолт;
5. Хувь хүний намтар;
6. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх лавлагаа, тодорхойлолт /e-mongolia.mn цахим системээс авсан байна/;
7. Цээж зураг (4х6 см) 2 хувь.

Дээр дурдсан баримт бичгийг дутуу бүрдүүлсэн, зохих ёсоор бүрдүүлээгүй иргэнийг бүртгэхгүй.

Дөрөв. Сонгон шалгаруулалт

1. “Шалгалт зохион байгуулах комисс” нь иргэнээс ирүүлсэн баримт материалыг судалж, Сонгон шалгаруулалтыг зохион байгуулна.
2. Шалгалт эхлэх өдөр, цагийг бүртгүүлсэн иргэнд И-мэйл болон утсаар мэдэгдэнэ.

**ТӨРИЙН ОРДОН,
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
Утас: 264550**